

Дэлхийн ой модыг хамгаалах цогц хандлага

Ойн Түншлэл нь **Европын холбоо** болон түнш орнуудын **хооронд** дэлхийн ой **модыг хамгаалах**, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахад чиглэсэн урт хугацааны улс төрийн зорилго бүхий хамтын ажиллагаа юм. Ойн Түншлэл нь ойн доройтол, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын хомсдол зэрэг тулгамдсан асуудлыг цогц, уялдаа холбоотой, нэгдсэн байдлаар авч үздэг бөгөөд үндэсний хүртээмжтэй хөгжлийг дэмжихэд чиглэдэг.

Зорилго

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой менежмент хийх
- Ойтой холбоотой нэмүү өртгийн сүлжээ, ажлын байр бий болгох
- Ойн хомсдолыг бууруулах
- Хууль ёсны, тогтвортой мод, модон бүтээгдэхүүний худалдааг дэмжих

Энэ талаар та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл

Европын Комисс, Олон улсын түншлэлийн ерөнхий газар, – Хүрээлэн буй орчин, байгалийн нөөц, усны F2 нэгж

Ирээдүйн төлөө ой төслийн нэгж (F4) нь Ази, Африк, Кариб болон Латин Америкт ойн эрүүл экосистем болон ойтой холбоотой нэмүү өртгийн сүлжээнд хувь нэмрээ оруулах техникийн дэмжлэг үзүүлдэг.



ЕХ-ны Олон улсын
хамтын ажиллагааны
газар – Ойн хэсэг

© Европын Комисс, 2022



Европын Холбоо Ойн Түншлэл

#ForOurPlanet #GlobalGateway



Ойд хөрөнгө оруулах нь

уур амьсгалын өөрчлөлттэй
тэмцэхэд чухал хөшүүрэг юм

Ойн Түншлэл нь тухайн түнш орны тэргүүлэх чиглэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн онцлог шийдлүүдийг санал болгож, урт хугацааны эерэг өөрчлөлтийг бий болгоход чиглэнэ:

- Ойг бодлогын тэргүүлэх чиглэлд тавих
- Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр, Биологийн олон янз байдлын конвенцид хувь нэмэр оруулах
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Ойн салбарын урт хугацааны зорилтуудад хүрэх



Copyright © GCCA/IEU 2019. Photo taken by Harvey Lisie
SOURCE: FAOSTAT2023
MarketResearch.com

Ойн тухай мэдээлэл

- 1.6 тэрбум**
Хүний амьжиргаа ойгоос хамаарч байна
- 31%**
Дэлхийн хуурай газрыг бүрдүүлдэг
- 80%**
уурай газрын биологийн олон янз байдлыг агуулдаг
- 420 сая га**
Ой 1990 оноос хойш утсан
- 1300 тэрбум Евро**
Дэлхийн ой модонд суурилсан нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн үнэлгээ

Урт хугацааны амлалт – илүү үр нөлөө

Ойн Түншлэлийн гол оролцогчид нь **Түншлэгч улс орны засгийн газрууд** болон **Европын Холбоо**. бөгөөд тэд эрх тэгш үндсэн дээр хамтран ажилладаг. Хамгийн тохиромжтой, үр дүнтэй түншлэлийг бий болгоход түншлэгч орнуудын нутгийн иргэд, уугуул иргэд, орон нутгийн засаг захиргаа, судалгааны байгууллагууд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөгчдийг хамруулна. Ойн Түншлэл нь хэрэгжилт, үр дүнгээ тайлагнах замаар ил тод, хариуцлагатай байдлаа хангадаг.

Суурь хүчин зүйлс



Ойн засаглал



Ойн нэмүү өртгийн сүлжээгээр ажлын байр бий болно



Хууль ёсны ба тогтвортой модон бүтээгдэхүүний худалдаа



Ойн хомсдол багасна



Биологийн олон янз байдал ба байгаль хамгаалал



Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх